

МОНГОЛ ХЭЛНИЙ ҮГҮЙСГЭХ ХАРЬЦАА БА ТҮҮНИЙ ИЛРЭХ ХЭЛБЭРҮҮД

Жанцангийн БАТ-ИРЭЭДҮЙ

Удиртгал

1. Монгол хэлний үгүйсгэх харьцааг судласан байдал
2. Монгол хэлний үгүйсгэх харьцаа ил илрэх нь
3. Монгол хэлний үгүйсгэх харьцаа далд илрэх нь
4. Монгол хэлний үгүйсгэх харьцаа хэлц үгээр илрэх нь

Дүгнэлт

Номзүй

Удиртгал

Үгүйсгэл буюу negation гэдэг бол хэл бүхэнд байдаг хэлзүйн хамгийн нийтлэг үзэгдлүүдийн нэг юм. Онолын хувьд хэлшинжлэлийн ойлголтоор батлах үгүүлбэрийн эсрэг утга заах бөгөөд дан үгээс нийлмэл үгүүлбэр хүртэлх бүх төвшинд үгүйсгэлийг хэрэглэж болох ба тухайн хэлний онцлогоос шалтгаалан өөр өөр арга хэрэглүүртэй байдаг. Хэлний хүүрнэх, батлах үгүүлбэрийн эсрэгцэл буюу үгүүлбэрийн эсрэг утгыг бий болгох зорилготой энэхүү харьцаа нь зарим хэлэнд тодорхой үгээр илэрдэг бол ихэнхи хэлэнд тусгай нөхцөлөөр илэрдэг. Давид Кристалын “Хэлшинжлэл, авиа зүйн толь бичигт, “Negation (negative) a process or construction in grammatical and semantic analysis which typically expresses the contradiction of some or all of a sentence’s meaning.” (David Crystal 1997:112) гэсэн байна. Монгол хэлний хувьд бол үгүйсгэх утга илэрхийлэх нөхцөл нь ч байдаг, үг нь ч байдаг онцлогтой хэл юм.

Аливаа хэлний үгүйсгэл бол хэлзүй, утга судлал, эх судлал дундын хамгийн чухал хэсгийн нэг. Хүн эхлээд хэлд орохдоо зөвшөөрсөн утга илэрхийлэхээсээ өмнө үгүйсгэх утга хэлж сурдаг бөгөөд дэлхийн олон хэлэнд үгүй хэмээх утга –n эсвэл –m үсгээр эхлэсэн байдаг нь хэлж дадах байдагтай холбоотой болох тухай судлаач Отто Жесперсен “Language : Its Nature, Development and Origin” номдоо бичжээ. Тухайлбал, Англи хэлэнд –not буюу –n’t, Франц хэлэнд ne... pas, Турк хэлэнд –me, Ненец хэлэнд –ni, Япон хэлэнд –(a)na- хэлбэртэй байх жишээтэй.

“International Encyclopedia of Linguistics” их тайлбар толь бичигт “Хэл бүхэн өөрийн гэсэн стандарт эсвэл өвөрмөц үгүйсгэлийн тогтолцоотой байдаг. Үгүйсгэлийн гол зорилго бол ердөө л энгийн үгүүлбэрийг үгүйсгэх утгад хувиргах гол үүрэгтэй. Үүнийг үгүүлбэрийн аль нэг гишүүнийг хувиргах юм уу, ямар нэгэн нөхцөл нэмсэнээр хувиргаж болдог.” (William Bright 1992:75) хэмээн дурджээ.

1. Монгол хэлний үгүйсгэх харьцааг судласан байдал

Монгол хэлний хувьд бол үгүйсгэх харьцаа үүсгэхдээ голдуу үгүүлбэрийн үгүүлэхүүн гишүүн буюу үгүүлэхүүний бүлэгт ямар нэгэн нөхцөл нэмэх замаар илрүүлдэг. Харин монгол хэл үгүйсгэх утгат нөхцлийн хувьд бусад хэлнээс харьцангуй олон хэлбэртэй бөгөөд тухайн нөхцлийн байр, үүрэг, онцлогоос шалтгаалан нөхцөл тус бүр өвөрмөц онцлогтой байдаг юм. Бид энэ үгүүлэлд энэ тухай дэлгэрэнгүй дурдаж жишээгээр батлах зорилго тавьсан болно. Үгүйсгэлийг зарим эрдэмтэд үгүүлбэрзүйн баймжийн айд багтаадаг бол зарим эрдэмтэд үгүүлбэрзүйд багтаадаггүй. Монгол хэлний үгүйсгэлийг эрдэмтэд дан үгүйсгэл, давхар үгүйсгэл, дундын үгүйсгэл гэх мэтээр ялган хэлэлцсээр ирлээ. Б.Пүрэв-Очир дан үгүйсгэлийг илрүүлэхдээ “тухайн гишүүний өмнө нь үл, эс-ийг, хойно нь үгүй, биш, бус-ыг хэрэглэж дан үгүйсгэл хэлбэртэй харьцааг үзүүлдэг.” (Пүрэв-Очир 1998:134) гэсэн байдаг бол давхар үгүйсгэлийн талаар А.Попов, Г.Ц.Пюрбеев, П.Аюушжав нар судалж, дундын үгүйсгэлийн талаар Б.Пүрэв-Очир бус, биш-ийг хэл, мэдэхүүний талаас нь сонирхолтой судалгаа хийжээ.

Нэрт эрдэмтэн, академич Ш.Лувсанвандан “Орчин цагийн монгол хэлний бүтэц” хэмээх бүтээлдээ “Хүний хэлэх янз бүрийн үгэлбэрийг бүтцийн хамгийн ерөнхий шинжээр нь аялга үгэлбэр, бүтэц үгэлбэр гэж хоёр ангилж болох мэт санагдана. Зарим үгэлбэрт үг, нөхцөл хоёр заавал оролцож, зарим үгэлбэрт үг, нөхцөл хоёр хэрэглэдэггүй байна. ... нөхцөл огт оролцохгүй бүтэх үгэлбэрийг бид бүтэц үгэлбэр гэж нэрлэв. Бүтэц үгэлбэр маш нарийн зохион байгуулалттай учир хэлний бүтцийг судлахад чухал бөгөөд сонирхолтой.” (Лувсанвандан 1968:11) гэжээ. Эрдэмтэн Б.Пүрэв-Очир “орчин цагийн монгол хэлний үгүүлбэрийг хэл, хэлэхүйн талын хамгийн ерөнхий шинжээр нь бүтэц, бүтэц бус өгүүлбэр гэсэн эсрэгцэлтэйгээр хоёр ангилж” (Пүрэв-Очир 2001:206) үзжээ. Ийнхүү ангилаад монгол хэлний бүтэц бус үгүүлбэр буюу нэрийн бүрэлдүүлбэргүй үгүүлбэрт үгүй, биш гэх мэт үгүйсгэсэн үгийг багтаасан байдаг юм. Энэ бол үгүйсгэх утгатай үгсийг үгүүлбэрийн хэмжээнд авч үзсэн ойлголт бөгөөд үүнийг зарим эрдэмтэд өгүүлбэр үг, зарим судлаач үгэн өгүүлбэр, зарим нь гишүүлбэргүй өгүүлбэр, бүр зарим нь ганц үгт өгүүлбэр гэх мэтээр тайлж, тайлбарлан хоёр ба нэг бүрэлдэхүүнт үгүүлбэрийн хэв маягт багтааж ирсэн нь бий. Ийм

үгүүлбэрийн гол шинж нь үгүүлбэрийн ямар нэг гишүүнээс бүтээгүй, үгүүлбэрийг тэр чигт нь хураан төлөөлсөн, өөртөө багтаасан, зөвхөн сул үг буюу үгүйсгэх зөвшөөх утгат мэдээлэл бүхий үгээр илэрдэгт оршино. Тухайлбал энд зөвхөн үгүйсгэх утгатай үгүүлбэрийг авч үзвэл, “Чи чинь малын бага эмч билүү? Бишээ, Танайх нэгдэлд ороогүй юм уу? Үгүй.” (С.Эрдэнэ, “Хулан Цамба хоёр”), “Аав аа, та дуран авч явах уу? – Үгүй, үгүй.” (П.Лувсанцэрэн, “Ус шиг цэнхэр”) гэх мэт байх жишээтэй. Ийнхүү монгол хэлний үгүүлбэрзүй судлаач Б.Пүрэв-Очир “Монгол хэлний ийм өгүүлбэр нь баталсан, үгүйсгэсэн, асуусан, анхааруулсан, зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн, эргэлзсэн, гайхсан, сэтгэлийн хөдөлгөөний өнгө аяс илэрхийлсэн зэрэг олон янз утгатай байна” (Пүрэв-Очир 2001:217) гэж тайлбарлаад үгүйсгэх сул үгийг багтаасан байдаг юм. Ийм учраас бид үгүйсгэх нөхцөл, болоод үгийг үгүүлбэрзүйн төвшинд авч үзэх нь зүйтэй хэмээн үгүүлбэрийн үгүйсгэх харьцааны ил болон далд илрэх талаар сонирхож байгаа юм.

Монгол хэлний үгүйсгэлийг гадаад, дотоодын эрдэмтэд нэлээд судласан. Тухайлбал, А.Попов, Г.Ц.Пюрбеев, Л.Мишиг, П.Бямбасан, Г.Гантогтох, Б.Пүрэв-Очир, М.Базаррагчаа, Ю.Мөнх-Амгалан, Ю.Вон Сү нарын зэрэг эрдэмтэд тусгайлан нарийн судлагаа хийжээ. Монгол хэлний үгүйсгэх утгыг судлахдаа ихэнхи эрдэмтэд дан гагц нөхцлийн талаас дагнан авч үзэж тайлбарлаж байсан бөгөөд үгүүлбэрийн үгүйсгэх харьцааг судласан нь харьцангуй бага байна.

Эрдэмтэн Б.Пүрэв-Очир үгүүлбэрийн үгүйсгэх харьцааг судалж “Монгол хэлний өгүүлбэр дэх өгүүлэхүүн ба өгүүлэхүүн бус харьцаатай гишүүд нь бүтэц өгүүлбэрийн дотор харьцааны утга илтгэхдээ нотлол хэлбэртэй ч байж болно, үгүйсгэл хэлбэртэй ч байж болно.” (Пүрэв-Очир 1998:134) гэжээ. Тэрбээр цааш нь “Мөн тухайн өгүүлбэрийн хүрээнд ч нэр ба үйл хэлхэцүүд өөр хоорондоо эсрэгцсэн байдалтай байж болно. Утга зохиолын хэлний баримтаас үзэхэд өгүүлэхүүн ба өгүүлэхүүн бус харьцааны аль аль нь үгүйсгэл хэлбэртэйгээр утгыг эсрэгцлийг илэрхийлдэг тийм өвөрмөц зүй тогтол ажиглагдаж байна. Харин монгол хэлний өгүүлбэрзүйн төвшинд илэрч байгаа дан ганц үгүйсгэл хэлбэр, тэрчлэн эсрэгцсэн утгатай үгүйсгэл хэлбэр, түүний утга, үүргийн онцлогийг бараг судалсангүй иржээ.” (Пүрэв-Очир 1998:135) гэжээ. Ер нь үгүйсгэх утгатай нөхцлүүдийг дан нөхцлийн хэмжээнд авч үзэж сул үг гэдэг айд авч үзэж судласан судлаач олон бий. Тухайлбал “Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал” номд судлаач Г.Гантогтох үгүйсгэх сул үг (Гантогтох 1987:136) гэж авч үзсэн байна. Ийнхүү монгол хэлний үгүйсгэх утга илэрхийлэх зарим нөхцөл тус бүрийг монгол судлаач З.К.Касьяненко, С.Галсан, П.Бямбасан, Г.Гантогтох, Ю.Мөнх-Амгалан нар зориуд тусгайлан судлажээ. Үүнээс, судлаач Ю.Мөнх-Амгалан “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай” номдоо *ул, эс, биш, бус, үгүй, -лгүй, -шгүй*, зэрэг нөхцөл, *алга* зэрэг үгийг баймжийн захын тогтолцоо буюу үндсэн баймж чанарт багтааж баймж утгын талаас

болон хэлзүйн талаас нарийн тайлбарлан бичсэн нь монгол хэлний үгүйсгэх утгатай нөхцөл болоод үгсийн нэлээд нарийн судалгаа болсон юм.

Ер нь бол монгол хэлний үгүйсгэх утгыг нөхцлөөр илэрхийлэх, үгээр илэрхийлэх, үгүүлбэр зүйн аргаар илэрхийлэх гэж гурав ангилж болох юм. Үгүйсгэх утгатай нөхцөлд –гүй, -лтгүй, -мгүй, -аагүй⁴, -уузай², -мааргүй⁴, -шгүй, гэх мэт багтах бөгөөд үгүйсгэх утгатай үгэнд байх, болих, битгий, биш, бус, бүү, ү/гүй, үл, эс, алга гэх мэт үг орно. Эдгээрийг судлаачид үгүйсгэх сул үг, үл хувилах дайвар үг, үгүйсгэх дайвар үг, угтан чимэх үг, үгүйсгэх үг гэх мэтээр янз бүрээр нэрлэсэн байдаг. Эрдэмтэн Ц.Өнөрбаян монгол хэлний үгүйсгэх утга илэрхийлэх зарим нөхцлүүдийг чимэх үгийн айд багтааж үгүйсгэн чимэх үгс (Өнөрбаян 2004:329) гэж тодорхойлсон байна.

Монгол хэлний үгүйсгэх утгатай үгүүлбэр болон үгүйсгэх сул үгийн талаар судлаач Ю.Мөнх-Амгалан “Ер нь, үгүйсгэх утга нь баглах утгын эсрэг зүйл бөгөөд үүний ерийн үгүйсгэл юм. Энэ нь батлах утга бүхий хураангуй өгүүлбэрийн загвар дээр үгүйсгэх сул үгийг нэмэх замаар илэрдэг. Иймэрхүү сул үгийн тоонд үл, эс, биш, үгүй зэргийг хамааруулна” (Мөнх-Амгалан 1998:200) гэжээ. Үгүйсгэх утгатай эдгээр нөхцөл, үгүүд нь дан ганц үгийг үгүйсгэх утгатай болгоно гэхээсээ илүү үгүүлбэрийн үгүйсгэх утга илүү заадаг учраас үгүүлбэрийн амьд харьцаанд авч үзэх учиртай. Ерөөсөө үгүйсгэл болоод баймж чанарыг үгүүлбэрийн амин холбоонд авч үзэж үгүүлбэрийн үгүүлэхүүн чанартай илүү холбон тайлбарлах нь зүйтэй юм.

2. Монгол хэлний үгүйсгэх харьцаа ил илрэх нь

Монгол хэлний үгүйсгэх утгатай нөхцөл, үг хэллэгийн хэлзүйн бүтэц, утга, хэрэглээний талаас Ж.Бат-Ирээдүй өмнөх сурах бичиг, гарын авлагуудад (Бат-Ирээдүй 2007:18-21), (Бат-Ирээдүй 2008:116-117) дэлгэрэнгүй дурдаж бичсэн билээ. Харин энэ удаа утга зохиолын хэлний төрөл бүрийн найруулга тэр дундаа уран зохиолын найруулгад өргөн хэрэглэгддэг үгүйсгэх утгатай үгүүлбэрээр жишээ баримтыг улам баяжуулан толилуулж байна. Доорх үгүйсгэх утга илэрхийлсэн нөхцөл болоод үгтэй жишээг монгол хэлний төрөл бүрийн ямар ч найруулгаас төвөггүй олж болно. Нөхцөл тус бүрийг жишээгээр авч үзье.

-гүй нөхцөл бол үгүй хэмээх үгүйсгэх утгатай үгийн товч хэлбэр бөгөөд нэр үг болон үйлт нэрийн дараа тохиолдож, үгүүлбэр төгсгөдөгөөрөө бусад нөхцлөөс онцлогтой. Жишээлбэл, “Хүн жаргал даадаггүй, зовлон даадаг”, “Тооногүй гэрт толгойгүй чавганц”, “Хүн гэхэд хүзүүгүй, хөхүүр гэхэд ёроолгүй”, “Зүү байгаад утасгүй, утас байгаад зүүгүй, гал байгаад илчгүй”, “Баян нь ядууг хайрлахгүй, ядуу нь баянг хайрлахгүй”, “Шар нүд нь урин зөөлөн харцтай байхыг би ер үзээгүй.” (С.Эрдэнэ, “Хулан бид хоёр”), “Энэ ямар учиртай бөгж гэж чи бодож байна?” – Мэдэхгүй.”

(*Д.Батбаяр*, “*Амрагийн тэнгэр*”), “Гэвч би тийнхүү чойжин буулгаж байхыг нь үзсэнгүй.” “Ингэж уярах юм гэж ер санасангүй.” (*С.Эрдэнэ*, “*Хулан бид хоёр*”), “Чи өглөөгүй байна шүү дээ гээд инээхэд нь нүүрний нь хамаг арьс атиралдан таталдах аж.” (*Ц.Түмэнбаяр*, “*Ганц бие хөгжимчин*”). Эндээс бид бүр нарийн задлавал *нэр үг + -гүй, үйл үг + -хгүй, -аагүй⁴, -сангүй⁴* гэх мэт хэлзүйн олон бүтцийг гаргаж болох бөгөөд бүгд үгүйсгэх утга илэрхийлнэ.

Үл хэмээх үг нь үйлт нэр, үйл үгийн цаг заах хэлбэртэй үгийн өмнө голдуу тохиолдоно. Үгүүлбэр төгсгөхгүй. Жишээлбэл, “Зуны цаг дор баруун дамнуурчны таван гудамжны шавар үлэмж, шээс баасны үнэр ханхлахуй нь үнэхээр түмэн багц хүжийг шатаавч үл дарагдмаар аа.” (*Д.Нацагдорж*, “*Ламбугайн нулимс*”), “Тус тусын ор дэвсгэр дээр унтсан хойно, мэдээжийн хэрэг хүүхэн хааяа хааяа зөөлөн ханиаж, ламын нойр үл хүрнэ.” (*Д.Нацагдорж*, “*Ламбугайн нулимс*”), “Мань хоёр ч үнэхээр ангаж цангаж явснаа мэдэрснээр үл барам, унасан мориндоо ч халуунд ус эргүүлэлгүй өнжөөх гэж байгаагаас бас мэджээ.” (*С.Дашидооров*, “*Оосор бүсгүй орчлон*”), “Энэ мөчөөс хойш хаан Жамухын алдар урван тэрслэгч хэнийг ч болов төрийн цээрлэл цааз үл тойрохын хууль болог.” (*Д.Намсрай*), “Хөдөлмөр хийхгүйгээр хаана ч үл амьдарна.” (*С.Эрдэнэ*), “Би чамд хайртай” гэж хэлүүлэх дуртай мөртлөө хэлэхээр үл итгэнэ. Би чамайг ирээсэй гэж хүлээдэг гэсэн атлаа очихоор үл оруулна.” (*Н.Өлзийбат*, “*Хаалга*”), “Тахилт уулын тагтад Гурван цэнхэрийн агуй бий. Тааж чадахгүй оньсого шиг мухар нь үл мэдэгдэнэ.” (*Н.Өлзийбат*, “*Азуй*”), “Хоёр гарт мэдээ байгаа эсэх нь үл мэдэгдэх.” (*Б.Бааст*), “Нас барсан юм уу гэтэл гэрт нь зул, зураг хөрөг үзэгдэхгүй, өөрөө ч энэ тухай үл ярина.” (*Б.Шүүдэрцэцэг*, “*Муу охин*”).

Бус – энэ үг өмнөх нэр үгээ голдуу харьяалах тийн ялгалд, заримдаа үйлдэх, гарах, өгөх оршихын тийн ялгал, эсвэл үндэс хэлбэрээр захирч ордог үгүйсгэх харьцаа илэрхийлэх утгатай бие даасан үг юм. Үгүүлбэр төгсгөж чадна гэхдээ нийтлэг биш. Жишээлбэл, “Бүх юм мөнх бус. Гагцхүү урлаг л мөнх” гэсэн үг бүхнийг хүлцэн, тэр ч бүү хэл үе үе над руу бүр ойртон ирж нэвт шувт ширтэн сэтгэл санаагийг минь уудалж аваад шавар болгочих гэж байгаа юм шиг харах түүний харцыг хэдэн цагаар тэсвэрлэн суухад хүргэсэн юм.” (*Д.Батбаяр*, “*Мөнхрөх хүсэл*”), “Харанхуй тэнгэрээс бус газраас огшин хөөрч байх шиг санагдав.” (*П.Сандуйжав*, “*Түйгүүл*”), “Нэг эрхэм хүн Занабазарын бүтээсэн Цагаан дарь эхийг олж өгвөл мөнгө хайрлахгүй, төгрөгөөр бус хатуу валютаар худалдаж авья гэж түүнд хэлсэнд Яримпил түүнийг яаж ийгээд олохсон гэж өдрийн бодол, шөнийн зүүд болов.” (*Г.Баасансүрэн*, “*Тэрбултан*”), “Өтгөс хуучид энэ хоёрын үгнээс бус үнэн юмгүй, өвөлжөө, зуслан, хаваржаа, намаржаа энэ дөрвөөс өөр явах газаргүй хэмээн санаж, хөмөрсөн тогооны доторхтой адил хөдөөгийн бүдүүлэг байдалд хүмүүжнэ.” (*Д.Нацагдорж*, “*Хуучин хүү*”), “Нас ахиж, сэтгэл зөөлрөөд ирэхийн цагт хүн өөрийнхөө ганц хар толгойг бус ёс жудгийг

эрхэмлэн хичээж, хорвоогийн жамаар уул овоондоо хүртэл сүшиглэн залбирч, бишрэх хоргодох юмтай болдог ажээ.” (*Б.Догмид, “Нутаг”*). Энэ үгүүлбэрүүдийг ажиглавал дээр нийлмэл үгүүлбэрийн бүтэц дэх эхний үгүүлбэр нь үгүйсгэх харьцааг зааж байхад нөгөө үгүүлбэр нь эсрэгцсэн харьцаа зааж байна. Ийм үгүйсгэлийг профессор Б.Пүрэв-Очир “дунд байрлалын буюу интерпозиционный негатив үгүйсгэл” (Пүрэв-Очир 1998:142) гэж нэрлэсэн байна.

Бүү – энэ үг үйл үгийн өмнө гэхдээ голдуу захирах хэлбэртэй үйл үгийн өмнө тохиолдоно. Үгүүлбэр төгсгөхгүй. Жишээ нь: “Амсар муутай саванд юм бүү хий, айвал бүү хий, хийвэл бүү ай, бага гэж бүү бард, их гэж бүү сүрд”, “Тарах хүүгээр гал бүү түлүүл”, “Та сэтгэлээ бүү гэгэлзүүл, санаагаа бүү самууруул.” (*Б.Бааст, “Эргүү хөх будан”*), “Найр наадамд зодог шуудаг өмсөнө гэж бүү горьд. Явцгаа. Адуун дээр гар гэжээ.” (*Б.Бааст, “Эргүү хөх будан”*), “Энэ зургийн учрыг ярих гэвэл барагдахгүй урт түүх болно гээд цааш нь надаас илүү дутуу юм бүү шалгаа гэх аятай.” (*Б.Бааст, “Үрлээ”*), “Эргэж ирэх үгүйг бүү мэд. Дайны газар хүн алуулчихдаг гэнэ.” (*С.Эрдэнэ, “Наран тогоруу”*).

Эс - хэмээх үгүйсгэх утгат үг нь цаг заах үйл үг, үйлт нэрээр илэрсэн үгүүлэхүүн, зэрэгцсэн нийлмэл үгүүлбэрийн төгсгөлийн бус үгүүлэхүүний өмнө, тус тус тохиолдоно. Жишээлбэл, “Талын айлууд болохоор хэний хаяагаар хэн өнгөрч, намаржааны замаар хэн өвөн сөөвөн гэж явааг юунаа эс андах вэ.” (*С.Удвал, “Ховор хүн”*), “Нэхэн санаваас би хүн чулууны тухай бодож буй эсвэл хүн чулуу миний тухай бодож буйн ялгааг эс ойлгов.” (*О.Дашибалбар*), “Аргаар аргаар явъя гэвч арга нь олодохгүй хорвоод амьтны амь тэвчиж буяны мөр дагахыг хичээн өөрийгөө номхотгон захиравч алдаа нүглийн аль алиныг тойрч эс чадав.” (*Б.Догмид, “Хөх тэнгэрийн зарлиг”*), “Хурган дотортой хүрэн торгон дээл нь элбэгдэж, ханцуй нь уртгасаныг эс тооцвол онцгой юм олж харсангүй.” (*Ш.Гаадамба*), “Үнэнүүдийн зөвхөн эвэр нь шоволзож хамар нь сарталзахаас өөр юу ч эс харагдана.” (*Б.Дариймаа, “Зандан ээжийг минь асуувал”*), “Шингэн цэнхэр утаа суунаглан цогшин унтарч байгаа галын дэргэд очиж суух зуураа би тэр хавиар хэн нэгэн бүсгүй хүний мөр олж харахыг хичээсэн хэдий ч өвс ногооны дундаас юу ч эс олж үзэв.” (*Б.Догмид, “Нэхэл хатуу орчлон”*) гэх мэт.

Үгүй энэ үг голдуу дангаараа хэрэглэгддэг, дээр бичсэнээр нэг бүрэлдэхүүнт бүтэц бус үгүүлбэрт оролцож “үгүүлэмжийн бүхэл агуулгыг үгүйсгэсэн утгаар хэрэглэгдэх” (Пүрэв-Очир 1998:208) нь элбэг. Үгүүлбэр төгсгөж чадна. Жишээлбэл, “Танайх нэгдэлд ороогүй юм гэж үү? Үгүй.” (*С.Эрдэнэ, “Хулан Цамба хоёр”*), “Өвлийн өвгөн аав танд алим, чихэр өгсөн үү? – Үгүй ээ.” (*Н.Өлзийбат, “Цас”*), “Та кофе уух уу? – За үгүй дээ.” (*Г.Аюурзана, “Шүтэн бишрэгч”*), “Чи дахиад л унтлагын өрөөг минь хүсээд эхлэвээ дээ? – Үгүй ээ, үгүй.” (*Г.Бадамсамбуу, “Явна”*), “Одоо

харагдаж байна уу? Үгүй.” (Д.Батбаяр, “Амрагийн тэнгэр”), “Алив найзаа, чи надад үзүүлээч, - Үгүй, -Наадах чинь жинхэнэ буу юм уу? Гийм, Хоёулаа хамт тоглох уу? – Үгүй.” (Н.Сүхбат, “Буу”), “Уранаа, хаалгаа тайл л даа. – Үгүй шүү.” (Н.Өлзийбат, “Хаалга”). Үгүй-гийн араас ээ, шүү, дээ, дэг, гэх мэт янз бүрийн нэмэлт хэлбэр цувран орж төрөл бүрийн баймж утга илэрхийлдэг. Зарим тохиолдолд үгүүлбэрийн цагаар төгссөн үгүүлэхүүний дараа бичигдэж үгүйсгэх утга заах тохиолдол бий. Жишээлбэл, “Би энэ мэтийн юм бодож явахдаа мөн энэ Жирмийн даваанд Хулантай уулзах юм гэж санасан ч үгүй.” (С.Эрдэнэ, “Хулан, Цамба хоёр”). Зарим тохиолдолд нэр үгийг үгүйсгэх утга илтгэнэ. Жишээ нь: “Салхи ч үгүй, чийг ч үгүй эл шөнийн нам гүмд Робинсон, Батлер хоёр задгай галын дэргэд сууж утаагүй улалзах дөл ширтэн байв.” (С.Эрдэнэ, “Буцааж авах эрх”).

Биш - энэхүү үгүйсгэх үг нь нэр үг, төлөөний үг, тэмдэг үг, тооны үг, үйлт нэрийн хойно тохиолдож үгүйсгэх утга заана. Үгүүлбэрийн төгсгөлд тохиолдоно. Мөн асуух үгүүлбэрт тохиолдож болно. Жишээлбэл, “Баян гэгч мөнх биш, баатар гэгч үргэлж биш”, “Ам хэлэндээ аав хөвүүн гэдэг боловч авир санаа нь адбиш өөр биш үү” (Монголын Нууц Товчоо, 166-р зүйл), “Гүнсэн эхнэрийн хормой сахисан эр биш байлаа.” (Ж.Даицэгвэ), “Миний хань нар, сар биш, мэдээж цэцэг навч ч биш.” (Н.Нямдорж), “Та ямар үндэстэн бэ? Таа л даа. Араб гэж тэр хүүхний хэлэхэд Дармаев толгой сэгсрэв. Тэгвэл турк. -Биш. Казак. -Биш. Энэтхэг. –Биш гэж хэлэв.” (Н.Надмид), “Энд тэнд өвдлөө гэж дандаа яншдаг юм. Авгай нарын ааш бааш барагдах биш.” (С.Эрдэнэ, “Атаархал”), “Хүний үзэх юм дуусах биш.” (Б.Бааст, “Гэрийн, хээрийн хоёр хар амт”), “Нүд нь нэг айхавтар гялалзаад байхаас биш сайн муу олон юм ярьж адарлаж хэдэрлэсэнгүй.” (Д.Маам, “Газар шороо”), “Айл малын анир бараагүй энэ эзэнгүй талд юу харахлаараа морь ийнхүү үүрсдэг билээ гэж бодох зуур өвгөн анилдах шахам явсан зовхи сормуусаа өргөн алсыг харвал ойрхон саахалтын зайтай газар адуу гэхэд адуу биш, чоно гэхэд чоно биш нэгэн зэгэл саарал амьтан огтхон ч хөдөлгөөнгүй хөндөлдөн зогсч байх нь тэр.” (Б.Догмид, “Нутаг”), “Аянга үл хөдлөнө. Хүмүүс дахиад гайхаш болов. Аянга биш мал хулгайлдаг албин чөтгөр буй болсон юм биш биз ээ? гэж тэд хэлэлцэв.” (Б.Бааст, “Гэрийн, хээрийн хоёр хар амт”), “Намайг таних ч биш, үгүй ч биш байгаа бололтой.” (С.Эрдэнэ, “Хулан Цамба хоёр”). Энэ нөхцөл нь ардаа баймж утгатай нөхцлүүдийг авч хүний сэтгэлгээний нарийн өнгө аяс илэрхийлнэ.

Битгий энэ нөхцөл бол голдуу үйл үгийн захирах хэлбэрийн өмнө тохиолдоно. Асуух үгүүлбэр болон үгүүлбэрийн бүрэн үгүйсгэл хэлбэрээр тохиолдоно. Жишээлбэл, “Гарах хүүгээр гал битгий түлүүл.”, “Зунд битгий суу, зуданд битгий сандар.”, “Олмыг нь асуулгүй ус битгий гатал, ончий нь ололгүй хэрэг битгий шүү.”, “Дүү минь, битгий ай, ах нь нэг ядарсан хүн байна гэж паргисан

дуугаар хэлэхэд Хонгор жалга руу орж ойртон очив.” (*Ч.Лодойдамба, “Тунгалаг Тамир”*), “Нэг мэдэхнээ түүнд, битгий хуц гээд хэлчихжээ.” (*Ц.Доржготов, “Шинэ кино”*), “Та битгий биеэ барь, чөлөөтэй хөдөлж, ярьж хөөрч болно шүү дээ.” (*Д.Батбаяр, “Мөнхрөх хүсэл”*) гэх мэт уран зохиолын төрөл бүрийн найруулгад элбэг тохиолдоно. Мөн элдэв төрлийн нэмэлт үг авч баймж утга илэрхийлэх боломжтой.

Байх хэмээх үгүйсгэх утгатай үг бол болих гэсэн үгтэй ойролцоо утгатай. Энэ үйл үг нь үгүйсгэх утга илтгэхдээ үгүүлбэрт бие даасан байдалтай хэрэглэгддэг юм. Жишээлбэл, “Ойгүй хүнд хэлсэн байсан хоёр адил, ёроолгүй саванд хийсэн байсан хоёр адил.” (*зүйр.*), “Цамба гуай наадамд морь уядаг хэвээрээ юу гэхэд, бүр байсан гэж Хулан хэлэв.” (*С.Эрдэнэ, “Хулан Цамба хоёр”*).

Алга энэхүү үгүйсгэх утгаг үг нь үгүй буюу –гүй-тэй ижил үүрэг гүйцэтгэх боловч хэлний зүйн хувьд хувирч харьцаанд ордоггүй учраас дан энэхүү байдлаараа хэрэглэгддэг билээ. Мөн голдуу байхгүй буюу байхгүй байна гэсэн үгтэй дүйх үгүйсгэсэн утга илэрхийлдэг. Жишээлбэл, “Ах дүүгээс асуувал алга болсон гэнэ шүү, үхэж үрэгдсэн бол өөрийн нь хүүрийг үзэх юм сан.” (*Д.Нацагдорж, “Учиртай гурван толгой”*), “Энэ лав хаямал гээгдмэл эд байх сүрлэн дээвэр нь доошоо цөмрөн юунд ч юм овоо торгоогдож байгааг хараад ийм юманд амьтай юм орогнох янз алга гэж дотроо гутрав.” (*До.Цэнджав, “Шэнь Жэнь орох зам”*), “Дорги байсхийгээд хөтөлгөө морьтой алга болж, нутаг хошууныхан бараг мартаж байтал гэв гэнэтхэн хөтөл хөсөгтэй хүрч ирдэг байна.” (*П.Пүрэвсүрэн, “Өшөө”*).

3. Монгол хэлний үгүйсгэх харьцаа далд илрэх нь

Дээрх үгүйсгэх утгатай үг, нөхцөлүүд утгын талаас, баймжийн талаас, үгүүлбэрийн найруулгын талаас тодорхой хэмжээгээр судлагдсан байдаг. Бидний энэ үгүүллийн бас нэг гол зорилго бол үгүйсгэлийн өөр нэгэн хэлбэр болох үгүүлбэрийн далд үгүйсгэлийн харьцааг хэрхэн ойлгох талаар энд саналаа бичихийг зорисон явдал юм. Ийм үгүйсгэлтэй үгүүлбэр утга зохиолын жишээнд элбэг тааралдана. Үүнийг бид үгүүлбэр дэх далд үгүйсгэх харьцаа гэж нэрлэж байгаа бөгөөд хэн, яах, хэрхэн, юу, хаа(на), гэх мэт асуух үгтэй үйл үгийн бүтэцтэй үгүйсгэл уран зохиолын жишээгээр батлагдаж байна. Жишээлбэл, “Хүмүүжил нь ийм гунихралтай байдлыг хүүчин хүү өөрөө бас яахин мэднэ. Хуучин феодал ба лам нарын гайг мөн хэрхэн танина.” (*Д.Нацагдорж, “Хуучин хүү”*), “Хөдөө талын зэрэглээ мяралзан жирвэгнэхийн дунд хэдэн өндөр юм сүүмэлзэн үзэгдэх нь харь газрын аяны хүний нүдэнд яахин даруй танигдана.” (*Д.Нацагдорж, “Хөдөө талын үзэсгэлэн”*), “Хэдийгээр ухаан сэргэлэн боловч зүүн хошууны захад хүрсэнгүй, баруун мөрний тэртээ гарсангүй, зөвхөн гурав дөрвөн өртөө эргэн тойрон газрын дотор

оршин суусан тул юуг үзэж мэдэж, юуг сонсох ажээ.” (*Д.Нацагдорж*, “Хуучин хүү”), “Сайн сайхан юманд гар хүрэхгүй ч гэсэн нүд хужирлая гэх бодол өөрийн эрхгүй ирдэг болохоор нутгийн харчуул Цогт гуайнхаар аандаа нэг буугаад мордоход Ундрамд буруу өгөөд яахав.” (*С.Удвал*, “Ховор хүн”), “Аймгийн сургуульд явж буй намайг ямар сайхан хувь заяа угтаж буйг хэн мэднэ.” (*С.Эрдэнэ*), “... өглөө үүрээр чилээгий нь гаргах, өдөр услах зэрэг хар бор ажил хийхээс өөр ямар тус хүргэх билээ.” (*С.Эрдэнэ*, “Хулан бид хоёр”), “Тэвч яг энэ үед хуучин Толь гүний хүррэн дээрээс буу үүрсэн, хоёр ташаандаа буу зүүсэн бас нэг, ийм гурван хүн шөнө гарч Ээж хайрханы зүг явж байсныг тэр хоёр яахин мэдэх билээ.” (*Т.Юмсүрэн*, “Ээж хайрханы дууль”), “Даан ч тэр талаар махан бие, цусан заяанд төрсөн хүний үрс яахин тааж мэдэх билээ.” (*Ц.Буянзаяа*), “Тэр дотроо миний тухай юу гэж бодож байсныг хэн мэдлээ.” (*Ж.Лхагва*), “Надад гомдоогүй биз... гэж хойноос нь хашгирвал өвгөн эргэн зогсож хаанаас даа гэх мэт мөрөө хавчжээ.” (*С.Эрдэнэ*, “Буцааж авах эрх”), “Фон Бургэн хувхай гарыг нь үнсэхчээ болоод, - Оготно минь, эрхэмсэг Марлен чамд дээдсийн ёсыг таниулж өгнө. Илүү хувцас эмэгтэй хүний үзэсгэлэнг нуудгийг юу андах аж гэж хавчгар цээжээ түрэн чангаар инээгээд ... гарч одов.” (*С.Эрдэнэ*, “Оготно нүхэн дэх сувд”), “Хн тэдний дүлий плитка харж тэнэг юм шиг гөлийж сууснаас багзаалын эрэстраанд ороод ногоотой шөл иднээ. За өлсөж үхэв л гэж.” (*Р.Ганбат*, “Хадлангийн оросууд”), “Тэгвэл хэдэн жил ч эрүүл энх явахыг хэн байг гэхэв.” (*С.Эрдэнэ*, “Баруун сарьдагийн Вансэмбэрүү”), “Товуу “Цахиурт чинь өртөө гаруй газар. Энэ хүртэл тэмээ тогтвол тогтчихоор хэдэн бага говь бий. Тэнд байхгүйг бодоход эндээс хаа холдоо аж.” (*С.Дашидооров*, “Оосор бүчгүй орчлон”), “-Чи надад уурлаагүй биз? гэж лавлан асуувал Батлер хамар дороо инээд алдаж хоёр гараа зөрүүлэн цээжээ тэврэн толгой сэгсэрч, - хаанаас даа, найз минь гэж өчив.” (*С.Эрдэнэ*, “Буцааж авах эрх”), “Би үнэнийг нь хэлээ биз дээ? –За хэн мэдэхэв.” (*Д.Намсрай*, “Шар усны үер”), “Арван долоохон нас юу байхав дээ.” (*С.Эрдэнэ*, “Хулан Цамба хоёр”), “Би яаж мэдэхэв дээ, аав минь” (*Т.Юмсүрэн*, “Ээж хайрханы дууль”), “Ийм арзайсан муухай хар юмыг хэн ч тоогоо аж.” (*С.Эрдэнэ*, “Гарам дээр”), “Зөвлөдөг ч гэж дээ, би юугаа зөвлөхөв”, “Хар багаасаа үйлдвэрт орж, сайдаж муудаж дассан хамт олноосоо холдоод би хаа очихов.”, “... амттай яриа ярьсаар үргэлж ойр явахын чинээ санасан намайг хормын төдий хуурсан үлгэр шиг явдал гэж яаж би санахав.” (*С.Хишигсүрэн*, “Шөнө шиг өдөр”), “Аймгийн сургуульд явж байгаа хүн дайнд явж байгаа биш боловч урьд байсан юм байтугай, хүн алга болчихдог ертөнцөд ямархан хувь заяа угтаж байгааг хэн мэдэх билээ.” (*С.Эрдэнэ*, “Наран тогоруу”), “Өөр хэрэгтэй юм байвал өргөдөл мөргөдөл гээд яахав, шууд хэлж байгаарай.” (*Б.Дариймаа*, “Ногоочин болсон түүх”), “Тасын дэгдээхэй хүнд тийм амархан дасдагыг хэн ч мэдлээ.” (*С.Эрдэнэ*, “Буцааж авах эрх”), “Энэ архи уу, тэр өдөр тэгэж зоригоо чангалаагүй бол

хаанаас...” (Ж.Отгонцагаан, “Нагац ах”), “Зүгээрээ, миний дүү, чам шиг боловсролтой хүн юу алзахав.” (Б.Шүүдэрцэцэг, “Муу охин”) зэрэг үгүүлбэрт байгаа хэн мэдэх, яахин мэдэх, хэрхэн таних, яахин даруй танигдах, хаа холдоо аж, хаанаас даа гэх мэт бүтцийг бид утгаараа үгүүлбэрийн далд үгүйсгэлийг илэрхийлж байна гэж үзэж байгаа юм.

Өөрөөр хэлбэл хэн мэдлээ гэдэг нь хэн ч мэдэхгүй, яахин мэднэ гэдэг нь яаж ч мэдэхгүй, мэдэх аргагүй, хэрхэн танина гэдэг нь танигдахгүй, өлсөж үхэв л гэж гэдэг нь өлсөж үхэхгүй, хаа холдоо аж гэдэг нь холдоогүй, хэн мэдэхэв гэдэг нь хэн ч мэдэхгүй, юу байхав дээ гэдэг нь юу ч биш, хэн ч тоогоо аж гэдэг нь хэн ч тоохгүй, юу алзахав гэдэг нь алзахгүй гэх мэт үгүйсгэх утгатай дүйнэ гэж үзэж байгаа юм. Энэхүү үгүйсгэх хэлбэр нь асуух төлөөний үг + үйл үг + -х вэ, -х вэ дээ, -аа аж, -в л гэж, -г гэхэв гэсэн бүтэцтэй гэж үзэж болох бөгөөд ярианы хэлэнд хураагдаж хэлэх, бичигдэх нь бий.

Монгол хэлний өөр нэг үгүүлбэр зүйн аргаар үгүйсгэх утга илэрхийлэх хэлбэр нь үйлдэх тийн ялгалын нөхцлөөр илэрхийлэх боломж байна. Энэхүү бүтцийг –аар⁴ ... үйл үг гэсэн байдлаар авч үзэж болох бөгөөд монгол хэлний өнөөгийн хэрэглээнд өргөн дэлгэр хэрэглэгдэж байгаа бүтэц билээ. Үүнийг судлаач Д.Бадамдорж “...монгол хэлний нэр үгийн үйлдэхийн тийн ялгалын нөхцөл бол өгүүлбэрийг бусад үг, өгүүлбэртэй холбож, саарыг хориглох, сайныг номлох утгатай хэвшмэл хэлц бүтээх онцлогтой байна.” (Бадамдорж 2007:199-202) гэж тайлбарласан юм. Ингээд монгол хэлний “Аягаа голохоор, аашаа гол.”, “Арван дугана барихаар арван үнээ тэжээ.”, “Биеэ засахаар билэгээ зас.”, “Бурмаар тэжээхээр урмаа тэжээ.” “Нойрмоглож суухаар ном уншиж суу.”, “Нулимс унагахаар нударга зангид”, “Нэр хугарахаар яс хугар”, “Сууж амрахаар явж амар”, “Чамлахаар чанга атга”, “Барж идэхээр мэргэ ид”, “Дэрээ элээхээр дэвсээ элээ”, “Ярихаар яв, хэлэхээр хий.” зэрэг хэвшмэл хэллэгүүдийг жишээ татсан байгаа. Бидний бодоход энэ бол гагц хэвшмэл хэлц бүтээх бус ерөөсөө ийм бүтэц буюу загвараар монгол хэлэнд үгүйсгэх утга илэрхийлж болох юм. Тухайлбал, Та үүнийг авахаар түүнийг ав гэснийг Та үүнийг авч/авах хэрэггүй, харин түүнийг ав гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл –х хэрэггүй гэсэн хэлзүйн задлаг бүтцийг бүрэн орлож чадах ойролцоо утгатай нөхцөлт бүтэц үүсэж байгаа юм. Тийм учраас дээрх хэвшмэл хэллэгүүдийг ч мөн ийм байдлаар задлан тайлбарлаж болох учраас бид үгүйсгэх утгыг хэл зүйн аргаар илэрхийлэх бас нэг боломж буюу хэлбэр гэж үзэж байгаа юм. Харин энэ нь монгол хэлний бичил эх болсон зүйр цэцэн үгийн бүтцэд их тохиолддог болох нь жишээнээс ил байна.

4. Монгол хэлний үгүйсгэх харьцаа хэлц үгээр илрэх нь

Өөр нэг үгүйсгэх утга илэрхийлдэг зүйл бол монгол хэлний тодорхой нэг хэлц үгс шууд үгүйсгэх харьцаа илэрхийлэх боломжтой гэж үзэж болно. Тухайлбал, буруу хойшоо, гонж, гонжийн жоо, өнгөрсөн хорвоо, үхсэн хойноо, хаанаас даа, юу гэж, яалаа гэж, яршиг, яахын гэх мэт хэлц үгс байна. Жишээлбэл, “Үхсэн хойноо Чингис хаан бол. Чингис шиг баатар адаглаад эхнэрээ зодохгүй байхсан.” (С.Эрдэнэ, “Хулан бид хоёр”), “Өвгөөн хоюулаа явах уу, ханиндаа гангар гунгар гэж явах нь зүгээр биш үү, тэгээд ч сайн эрсүүд уруу татахгүй. Намайг явахад ч харин гонжийнжоо шүү дээ гэж Яринпил хэлэв.” (Р.Ганбат, “Хадлангийн оросууд”), “Буруу хойшоо гэж, Банзарын хэл сураг авчрах ч өнгөрсөн хорвоо.” (Б.Дариймаа, “Зандан ээжийг минь асуувал...”), “За за яршиг, ийм амьтантай толихолцож яахийн?” (Д.Намсрай, “Шар усны үер”), “Хаанаас даа, энэ чинь сумаас нааш ирж яваа хүн байна.” (С.Эрдэнэ, “Хулан бид хоёр”) гэсэн үгүүлбэрт байгаа үхсэн хойноо, гонжийнжоо, буруу хойшоо, өнгөрсөн хорвоо, яахийн, хаанаас даа хэмээх үгс нь биш, үгүй шүү дээ, хэрэггүй, чадахгүй дээ, -хгүй гэсэн үгүйсгэх утга илэрхийлэх тул монгол хэлэнд иймэрхүү үгүйсгэсэн утгатай тусгай үг байж болохыг харуулах бодит жишээ юм. Эдгээр үгнүүд зөвхөн үгүүлбэрийн бүрэлдэхүүнд багтаж, эхийн төвшинд эсвэл ярианд хэрэглэгдэж байж үгүйсгэх харьцаа заах учраас үгүүлбэрийн үгүйсгэх харьцаа илтгэх утгат хэлц үг гэж тодорхойлж болох юм. Мөн эдгээр үгүйсгэх утгат хэлц үгс нь ардаа даа², шүү, бэ, хөөрхий, зэрэг төрөл бүрийн үг авч баймж утга илтгэж чадна. Хамгийн гол нь эдгээр үгийн нь цөм бүтцэд нь үгүйсгэх утга хадгалагдан байгаа учраас хэлний хэрэглээнд зөвхөн үгүйсгэх утгаараа л хэрэглэгддэг, өөрөөр хэлбэл батлах, эсвэл асуух зэрэг утга руу хэзээ хувирч өөрчлөгддөггүй онцлогтой юм.

Дүгнэлт

Монгол хэлний үгүйсгэх харьцааг гадаад, дотоодын эрдэмтэд нэлээд судласан боловч бүрэн цогц боловсорсон судалгаа хараахан гараагүй байна. Бид энэ үгүүлэлд монгол хэлний үгүйсгэх харьцаа нэг талаас тусгай нөхцөл болон үгийн тусламжтайгаар ил илэрч болно. Харин нөгөө талаас эхийн төвшинд далд илрэх бололцоо нь хэлзүйн тодорхой бүтцээр хэлбэржиж болохыг утга зохиолын хэлний баримтаар батлахыг оролдлоо. Тухайлбал, Нэгдүгээрт, монгол хэлний үгүйсгэх харьцааг ил илэрхийлэх – гүй, -лгүй, -шгүй, -аагүй⁴, -уузай², -мааргүй⁴, гэх мэт нөхцөл, байх, болих, битгий, биш, бус, бүү, үгүй, үл, эс, алга гэх мэт үг өргөн хэрэглээтэй байгааг утга зохиолын хэлний баримтаар батлахыг зорилгоо. Монгол хэлний үгүйсгэх харьцаа нөхцөл болон үгээр илрэх бололцоог эрдэмтэд тусгайлан сайн судласан билээ. Хоёрдугаарт монгол хэлний үгүйсгэх харьцааг далд илрэх боломж байгаа эсэхийг анзаарч юуны өмнө гурван зүйлээр нотлохыг хичээлээ. Үүнд

нэгдүгээрт нь асуух үг + үйл үг гэсэн бүтэцтэй *яхин мэдэх, хэрхэн таних, юуг мэдэх, хаанаас ойлгох, хэзээ яах, юу андах, хэн байг гэх, хаа холдох, юугаа хийх* гэх мэт үгс үгүйсгэх харьцаа далд илэрхийлнэ. Удаахад нь үйл үг + –аар⁴ үйл үг гэсэн хэлзүйн бүтцээр илрэх хэлэхээр хий, суухаар яв, бацлахаар мэр гэх мэт загварыг үгүйсгэх утга далд илэрхийлнэ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл энэ бүтэц нь хэлэх хэрэггүй хий, бацлах хэрэггүй мэр гэсэн утга илэрхийлж байгаа гэж үзэж байна. Мөн үгийнхээ цөм буюу гүн бүтцэндээ үгүйсгэх утга хадгалж байдаг зарим хэлц үг нь үгүүлбэрийн үгүйсгэх харьцаа илэрхийлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд гонжийн жоо, хаанаас даа, буруу хойшоо, яалаа гэж гэх мэт олон үгс бий. Ийнхүү монгол хэлний үгүйсгэх харьцааг ил болоод далд илэрхийлэх боломжийг зарим талаар нягтлан үзэж утга зохиолын хэлний жишээ баримтаар баяжуулан судлаачдын анхааралд танилцуулж байна.

НОМЗҮЙ

- Бадамдорж, Д (2007), “Монгол хэлний утгазүйн шинжилгээ”, Улаанбаатар.
- Баг-Ирээдүй, Ж (2008), “Монгол хэлний хэлзүйн сан”, ред. К.Окада, Улаанбаатар.
- Баг-Ирээдүй, Ж (2007), “Монгол хэлний үг, утгын сан”, ред. К.Коппе, Улаанбаатар.
- Бямбасан, П (2006), “Монгол хэлний онол, бүтцийн асуудалд”, Улаанбаатар.
- Лувсанвандан, Ш (1968), “Орчин цагийн Монгол хэлний бүтэц (Үг, нөхцөл хоёр нь)”, Улаанбаатар.
- Мишиг, Л (1978), “Орчин үеийн Монгол бичгийн хэлний дадлагын хэлзүй”, Улаанбаатар.
- Мөнх-Амгалан, Ю (1998), “Орчин цагийн монгол хэлний баймжийн ай”, Улаанбаатар.
- Өнөрбаян, Ц (2004), “Орчин цагийн монгол хэлний үгзүй”, Улаанбаатар.
- Гантогтох, Г (1987), “Орчин цагийн монгол хэлний үгзүйн байгуулал”, Улаанбаатар.
- Пүрэв-Очир, Б (1998), “Монгол хэлний өгүүлбэрзүй II”, Улаанбаатар.
- Пүрэв-Очир, Б (2001), “Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүй I”, Улаанбаатар.
- David Crystal (1997), *A Dictionary of Linguistics and Phonetics*, Fourth Edition, Oxford, Blackwell Publishing.
- John C. Street (1963), *Khalkha Structure*, The Uralic and Altaic Series, Vol. 24, Bloomington, Indiana University (The Hague : Mouton).
- Gisaburo N. Kiyose (1995), *Japanese Grammar - A New Approach*, Kyoto, Kyoto University Press.
- Otto Jespersen (1975), *Language : Its Nature, Development and Origin*, New York, W.W. Norton & Company.
- Trask R.L. (1993), *A Dictionary of Grammatical Terms in Linguistics*, London & New York, Routledge.
- William Bright (1992), *International Encyclopedia of Linguistics*, Vol. 3, New York, Oxford University Press.
- Wonsoo Yu (1991), *A Study of Mongolian Negation*, Ann Arbor, University Microfilms International Dissertation Information Service (Indiana University).
- Yamada Masamichi (2003), *The Pragmatics of Negation : Its Functions in Narrative*, Tokyo, Hituzi Syobo.

モンゴル語における否定関係とその出現形式について

BAT-IREEDUI, Jantsan

筆者はこの論文で従来あまり研究されてこなかった現代モンゴル語の否定関係あるいは否定 (negation) の研究に注意をかたむけた。モンゴル語の否定関係をあらわす接尾辞と語について、A.ポポフ、G.Ts.ピュルペーエフ、Z.K.カシヤネンコ、L.ミシグ、ユ・ウォンス、G.ガントグトフ、B.プレブオチル、Yu.ムンフアムガランなどのモンゴル語学者がこれまで研究してきた。

この論文では：

1. モンゴル語の否定に関する従来 of 学者の研究を詳細に検討し、その概略を提示した。
2. 否定の意味をあらわす接尾辞 (-гүй, -лгүй, -мгүй, -ааргүй⁴, -уузай², -мааргүй⁴, -шгүй など) と語 (байх, болих, битгий, биш, бус, бүү, /ү/гүй, үл, эс, алга など) を登録し、標準語の資料によって例証した。
3. モンゴル語の文体論で否定の意味が暗示的にあらわれる三つの可能性について例証することをめざした。

まず第一に、юуны өмнө, яахын мэдэх, хэрхэн таних, юу үзэх, юуг сонсох, яахин таах, хэн мэдэх, юу андах, -в л гэж, хаа холдох といったような、疑問詞の次に動詞がくる文法構造が否定の意味を暗示的にあらわしていると考えた。第二に、[-аар⁴ ... 動詞] という文法構造も同じように暗示的な否定をあらわすと考えた。たとえば、“Аягаа голохоор аашаа гол”, “Барж идэхээр мэргэ ид” といったような慣用文にある -оор гол, -ээр ид のような構造がふくまれる。第三に、モンゴル語の慣用的な意味を持ついくつかの語句の中には、否定の意味だけしかあらわさないものがあると考えられる。たとえば、буруу хойшоо, гонж, гонжийн жоо, өнгөрсөн хорвоо, яршиг, яахын といったような語句がふくまれる。これらを標準語の確固たる資料によって例証した。

以上、筆者は、モンゴル語の否定の意味が明示と暗示という二つの表現方法によって現出し、明示的表現が接尾辞や語によってあらわれるのに対して、暗示的表現は文法上の一定の構造によってあらわれると考えている。